

ҮЗМЭРЭЭС СУРАЛЦАХУЙ



Хүүхдийн шавхагдашгүй дотоод нөөцийг илрүүлэн хөгжүүлж, Монгол хүн болгон төлөвшүүлж чадвал бидний хүн амд зориулан зохиож буй ажлын зорилго биелэх юм. Музейн олон нийтийн үйл ажиллагаа, түүний дотор боловсролын ажлын үр өгөөжийг сайжруулан, хүн амд үзүүлэх үйлчилгээнийхээ хүртээмжийг дээшлүүлэхийг тулд музейн ажилтнууд боловсролын ажлын онол, гадаадын болон өөрийн орны музейнүүдийн туршлагыг судлан нэвтрүүлэхийг зорьж байна.

Та бүхэнд хүргэж буй “Үзмэрээс суралцахуй” дасгал ажлын хүснэгтийн ач тус нь хүүхдүүд музейн үзмэрийг үзэхдээ сонирхон ажиглах, бүтээлчээр хандан судалж, физик шинж чанар, бүтэц, зориулалт, бүтээгдсэн арга ажиллагаа, үнэ цэнэ зэрэгт анализ дүгнэлт хийж сурахад байдаг. Үзмэрийг зөвхөн үзээд зогсохгүй гараар барих, харьцуулах, харилцан ярилцаж суух нь сэтгэлд нь илүү ойр үлддэг.

Монголын Үндэсний Музейн “Монголын уламжлалт соёл” танхимд буй уламжлалт **Хорол, Үйчүүр, Алаг мэлхий** тоглоомуудыг “**Нүүдлийн музей**” төслийн хүрээнд хэрэгжсэн “**Монгол наадгай**” хөтөлбөрт зориулан хуулбарлаж, сургуулийн сурагчдад барьж тоглуулах, судлуулах боломж нөхцлийг бүрдүүлсэн.

Цагаан сарын баяр болон “Дээлтэй Монгол” баярын өдрөөр сургууль, цэцэрлэгүүд музейд өгсөн захиалгын дагуу ирж, музейд үзээд тоглож байна. Бидний явуулж буй боловсролын ажилд үзмэр судлах хөтөлбөр байдаггүй. Тиймээс дараах дасгал ажлын хуудсыг ашиглан хөтөлбөр боловсруулахад хэрэг болох бол уу гэсэн үүднээс хэвлүүлж байна.

Та хүүхдүүд үзмэр судлан шинжилж эхлэхэд энэхүү дасгал ажлын хуудсыг загвар болгон өгч болно. Дасгал ажлыг хийснээр тэд өөрсдөө асуулт тавьж, хариулж сурах юм.

Доорх дасгал ажлын хуудсыг “Музейн үндэс” гарын авлагад Гэйл Дурбин, Сюзан Моррис болон Сью Вилкинсон нарын “Үзмэрээс суралцахуй” Багшийн гарын авлага. Английн өв. 1990. (Gail Durbin, Susan Morris and Sue Wilkinson A Teacher’s Guide to Learning from objects, English Heritage, 1990) номоос авчээ.

Үзмэрийг үзэх нь

Үндсэн асуултууд	Зарим нэмэлт асуулт	Олж харах зүйлс	Судлах зүйлс
Физик шинж чанар Энэ ямар үзмэр вэ?	Ямар өнгөтэй вэ? Ямар үнэртэй вэ? Ямар дуу чимээтэй байна вэ? Ямар материалаар хийгдсэн вэ? Байгалийн гаралтай юу, бүтээгдсэн зүйл үү? Бүрэн бүтэн үү? Хэлбэр дүрс нь өөрчлөгдсөн үү, өөр болгосон байна уу, сэлбэн засагдсан уу, элэгдэл байна уу?		
Бүтэц Хэрхэн бүтээгдсэн вэ?	Гар аргаар уу, машинаар уу? Хэвэнд цутгасан уу эсвэл тус тусад нь бүтээсэн үү? Хэрхэн нийлүүлсэн бэ?		
Зориулалт	Юунд хэрэглэдэг байсан бэ? Зориулалт нь өөрчлөгдсөн уу?		

<p>Загвар дизайн</p> <p>Сайн загвар дизайнтай байна уу?</p>	<p>Анхны загвар нь сайн байсан уу ?</p> <p>Хамгийн сайн материалаар бүтээгдсэн үү?</p> <p>Чимэглэсэн байна уу?</p> <p>Харагдах байдал нь танд таалагдаж байна уу?</p> <p>Өөр хүмүүст таалагдах болов уу?</p>		
<p>Үнэ цэнэ</p> <p>Энэ нь үнэ цэнэтэй юу?</p>	<p>Бүтээсэн хүний хувьд?</p> <p>Эдэлж хэрэглэж хүний хувьд?</p> <p>Хадгалж байгаа хүний хувьд?</p> <p>Таны хувьд?</p> <p>Банканд?</p> <p>Музейд?</p>		

С.Буянжаргал

Музей судлалын мэргэжил арга зүйн төвийн арга зүйч
 Timothy Ambrose and Crispin Paine. Museum basics.
 London and New York. 1995. Page 44.